



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 25 өдөр

Дугаар А/649

Хэрлэн сум

Аймгийн “Оны шилдэг” шалгаруулах үйл ажиллагаанд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалт, аймгийн Засаг даргын 2015 оны А/562 дугаар захирамжаар баталсан Оны шилдэг ажилтан, байгууллага шалгаруулах журмыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн 2024 оны шилдэг ажилтан, байгууллага шалгаруулах ёслолын арга хэмжээнд зориулж 29,626,000 (хорин есөн сая зургаан зуун хорин зургаан мянга) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх арга хэмжээний зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн урьдчилан төлөвлөх боломжгүй нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Өнөрцолмон)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.АЮУРБУНЬ



Аймгийн Засаг даргын 2024 оны
12 дугаар сарын 25 -ний өдрийн
А1679 дугаар захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

№	Нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Мөнгөн дүн /төгрөг/
1	Шилдэг байгууллага /Мөнгөн шагнал/	3	1,000,000	3,000,000
2	Шилдэг ажилтан /Мөнгөн шагнал/	8	300,000	2,400,000
3	Өргөмжлөл	3	107,000	321,000
4	Цом	8	180,000	1,440,000
5	Урилга	250	4,000	1,000,000
6	Хөөсөн хэвлэл	12	25,000	300,000
7	Заал, танхимын түрээс	-	-	4,650,000
8	Хөгжим, аппаратур, тайз гэрэлтүүлэг түрээс	1	14,500,000	14,500,000
9	Салют	2	607,500	1,215,000
10	Угталтын үүдний баннер	1	800,000	800,000
	Нийт дүн			29,626,000